



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл
хэрэгжүүлэх гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн
хуралд санал болгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 4.2 дахь заалт Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр ирүүлсэн ХЭГ/989 тоот албан бичиг, Авлигатай тэмцэх газрын 2023 оны 05/8294 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Засгийн газрын хэрэг эрхлэх газрын шинжээч Бат-Эрдэмийн Төрбатыг томилуулахаар “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд санал болгосугай.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ